



СОЁЛ ХООРОНДЫН ХАРИЛЦААНЫ ҮНДСЭН АСПЕКТУУД



(Монгол, Герман үндэстний жишээн дээр)

МУБИС-ийн Гадаад хэлний сургуулийн Англи хэл,
Америк судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд
профессор Б.Тунгалаг

ХИС - ийн багш, магистр Б. Болормаа

Abstract

This article intends to discuss the basic aspects of intercultural communication such as language role and different traditions to keep the native language use more sustainable, educational level, communication patterns and different methods of delivering information, speech acts and patterns, and body language and its interpretations which cause misunderstanding to communicate in both Mongolian and German cultures. In dealing with intercultural communication, awareness of these aspects of each culture, how they are the same, and how they are different is important. When cultures interact, it is absolutely necessary (1) to give a better understanding about Mongolian and German cultures; and (2) to contrast the most important cultural aspects of the two cultures.

Key words: intercultural communication aspects, comparison of Mongolian and German cultures

1. Монгол, Герман харилцагчдын соёлыг харьцуулах асуудал

Аливаа соёлын талаар ерөнхийлөн хэлсэн зүйл, стереотип (хэвшмэл буюу тогтсон) ойлголтуудаас үүдэн гарч болох асуудлыг авч үзэхгүйгээр бүхэл бүтэн ард түмнийг тодорхойлно гэдэг бол эргэлзээ байхгүй хэцүү асуудал юм. Тухайн асуудлын талаар өргөн хүрээтэй, нийтлэг болон ялгаатай байдлыг тодорхойлсон ямар ч дүрслэл ямар нэгэн шүүмжид өртөх нь зүй ёсны асуудал юм. Учир нь бид энэхүү өгүүлэлдээ монгол, герман соёлын тухайд эсрэгцүүлэн авч үзсэн ажиглалт болон хуримтлуулсан туршлагын талаар өгүүлж байгаа билээ. Монгол, герман үндэстний тухай, ялангуяа Монголын тухай түүх, эдийн засаг, нийгэм, соёлын талаас нь Германы монголч эрдэмтдийн задлан шинжилсэн олон тооны бүтээл¹ хэвлэгдсэн байдаг ч бидний судалгаа

¹ Германд монгол судлал Монголын аман ба бичгийн дурсгалыг судлах ажлаар эхэлсэн бөгөөд энэ салбар нь өнөөдрийг хүртэл Германы монгол судлалд хүндтэй байр эзэлсэн хэвээр байна. Германы талаас Монгол судлалд үнэтэй хувь нэмэр оруулсан эрдэмтдийн тоонд В. Хайсиг, Б. Шпулер, У.Б. Баркманн нарын эрдэмтэд зүй ёсоор тооцогдоно. В. Файт, У. Б. Баркманн нарын сэдэвчилсэн бүртгэлээс үзэхэд, 1996 оныг хүртэл монгол судлалаар Германы эрдэмтдийн бичсэн 765 бүтээл нийтлэгдсэн байна (Ц. Ишдорж 2004, 154). Өнгөрсөн 100 гаруй жилийн дотор Германд Монголыг судалдаг эрдэмтэд төдий л олон биш байсан боловч тэдний гаргасан бүтээл нь арвин их бөгөөд эрдэм шинжилгээний өндөр түвшинд бичигдсэн байна. Эрдэмтдийн гаргасан бүтээлийн тоо харилцан адилгүй байх юм. Тухайлбал, В. Хайсиг 253 бүтээл нийтлүүлсэн

соёлыг тодорхойлох болон харьцуулахад гарсан нэгдсэн саналын талаарх ойлголттой эсрэгцэж буй юм.

Соёл хоорондын харилцааны сэдвийг авч үзэх нь нийгмийн салбарын бүхий л түвшинд харилцаа, хамтын ажиллагааг аль болох боломжийн хэмжээнд явуулахад чухал юм. Тиймээс ХБНГУ-аас Монгол улсын хөгжлийн бодлогын хүрээнд төсөл хэрэгжүүлэгч байгууллага болох Германы Техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн ажилтнуудад зориулсан “монголчуудтай хэрхэн харилцах” талаар боловсруулж гаргасан заавар, зөвлөмж, удирдамж нэлээд хэдэн удаа хэвлэгдэн гарч, ХБНГУ-аас манай улсад хөгжлийг дэмжих албан ёсны хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор ажиллахаар ирсэн германы мэргэжилтнүүд нь соёл хоорондын харилцааны чиглэлээр сургалт, семинарт хамрагдан Монголын талаар тодорхой мэдээлэлтэй ирдэг. Монголын талаар мэдээлэл авах гол хэрэглэгдэхүүн материал нь германчуудын хувьд аян замын тэмдэглэл, ном зохиол, бусад мэдээллийн хэрэгсэл байна. Тухайлбал, *Mongolei* (Штеллинг/Форкерт 2004), *Verbalten in der Mongolei* (Борманн Ренате/Борманн Клаус-Дийтер 1998) г.м. олон ном товхимолд монгол хүнтэй хэрхэн харилцах тухай заавар зөвлөмж орсон байх юм. Харин монголчуудад зориулсан Герман орны тухай ном зохиол, заавар, зөвлөмж хэвлэгдэн гарсан нь тун цөөн байдаг.

‘Герман үндэстний зан чанарын’ тухай германы философичид зохиол бүтээлдээ тод томруун тусгасан байдаг. Кант (*Reine Vernunft*) өөрийн ёс суртахууны сургаалдаа зан суртахууны үйлдлийн зарчмуудыг авч үзсэн байдаг. Герман үндэстний тухай нийтэд түгсэн ойлголт бол германчууд нь цаг барьдаг, эмх цэгцтэй, арвич хямгац, хүйтэн хөндий, хошин наргианч буюу алиа хошин биш гэх мэтээр олонтаа дурдсан байдаг.

Монголчуудын нүүдлийн аж амьдрал, аж төрөх ёс, соёл, сэтгэлгээний онцлогуудын талаар Монголын философич, сэтгэгч В. Инжинааш, Д. Равжаа, Тогтохтер ван нарын олон арван эрдэмтэн өөрсдийн бүтээлдээ тодорхой бичсэн байдаг. Монголын соён гэгээрүүлэгч Дулдуйтын Данзан Равжаагийн бичсэн “Цагийн жамыг тодруулагч Цаасан шувуу” хэмээх сургаалын үр нөлөө Монголын ард түмний туулж өнгөрүүлсэн амьдралын түүхэн хөгжлийн явцад ул мөрөө үлдээж, Монголчуудын зан байдал, оюун болон

байхад Б. Шпулер эрдэм шинжилгээний хувьд их үнэ цэнтэй 3 тооны бүтээл – “Алтан Ордоны улс, Монголчууд Орос оронд (1223-1502 он)”; “Монголын үе”; “Иран дахь Монголын Хаант улс (1220-1350)” - нийтлүүлсэн байна.



ахуйн сэтгэлгээнд гүн гүнзгий нөлөө үзүүлсэн байдаг. Тэрээр Д. Равжаа өөрийн туурвисан сургаал-үлгэрт ёс суртахууны гол гол үзэл санааг тусгахдаа: “Хүмүүний явдал мөр буюу хүмүүн хоорондын харилцааг хэрхэн яаж үнэлэн цэгнэж авч үзэх, юуг сайн муу, худал үнэн гэх зэрэг ёс суртахууны үнэлэмжүүдийн” талаар тодорхойлсон байна. Эдгээр ёс суртахууны сургаал, чанарууд нь амьдралын бүхий л салбарт илрэх монголчуудын зан байдлын нэг тогтсон хэсэг болжээ.

Дээрх асуудлын талаар дэлгэрүүлэх шаардлага байгаа хэдий ч харилцааны чухал аспектуудыг зааглах зорилгоор энд зарим нэг харьцуулалтын шалгуур хэмжүүрийг авч үзэх шаардлагатай байна. Юуны өмнө монголын болон германы соёлд хэл ярианы ач холбогдол янз бүр байсныг тодруулан судлах нь зүйтэй болов уу.

2. Монгол, Герман харилцагчдын соёл хоорондын харилцаан дахь чухал аспектууд

2.1 Хэлний үүрэг

Монгол-герман хэлийг зэрэгцүүлэн судлах чиглэлээр цөөн тооны судалгааны бүтээлүүд хэвлэгдэн гарчээ. Монгол хэл, соёлыг судлах эхлэл нь ХБНГУ-ын Берлин хотын Хумбольдтын нэрэмжит их сургууль, Бонн хотын их сургуульд Төв Ази судлалын институт байгуулагдаж, Монгол судлалын анги нээгдсэн үеэс тавигдсан. Энэ үеэс Монгол судлал, нарийвчлан хэлвэл, Монголын аман ба бичгийн дурсгалыг судлах ажлаар Германд монгол судлал хөгжиж эхэлсэн байна. Монгол хэл аялгууны судлалаар Германы монголч эрдэмтдийн хэвлүүлсэн дорвитой бүтээл туурвилуудад М. Вайерсийн бичсэн “*Untersuchungen zu einer historischen Grammatik des protoklassischen Mongolisch*” (Бонн 1996), У. Баркманны “Монголын нууц товчоон дахь андгай тангарагийн асуудлын талаар хийсэн зарим тэмдэглэл” (*Einige Bemerkungen zum Problem des Eides in der «Geheimen Geschichte der Mongolen»* 1991), Ренате Бауве-Раднаагийн “Монгол хэлний гишүүн болон хавсарсан нийлмэл өгүүлбэр дэх өгүүлэгдэхүүний заахын хийгээд харьяалахын тийн ялгал” (*«Akkusativ und Genitiv des Subjekts in mongolischen Glied- und Nebensätzen»* 1969), Г. Дөрферийн “Монгол бичгийн хэл” (*Die mongolische Schriftsprache* 1964) зэрэг бүтээлүүд орно.

XIX зууны сүүлч, XX зууны эхэн үеэс Монголчууд өрнөдийн соёл иргэншилтэй танилцаж эхэлсэн билээ. 1920 оноос 1930-аад онуудад Германд суралцаж ирсэн залуучууд анх Монголын герман судлалыг хөгжүүлэх эхлэлийг тавьжээ. 1930-аад онд Я.Цэвэл Герман-Монгол хэлний толь бичиг зохиож, Д.Нацагдорж тэргүүтэй залуу сэхээтнүүд латин үсгийн ном бичиж, Б.Ринчен Я.Вассерманн, Стефан Цвейгийн зохиолуудаас орчуулж байв. Энэ уламжлал өргөжин тэлж, монголын олон мянган залуус эдийн засаг, нийгэм, улс төр, хууль эрхзүй, анагаах ухаан, инженер, техник, хими, физик, математикийн чиглэлээр хуучнаар БНАГУ-д нарийн мэргэжил эзэмшин ирж тухайн чиглэлийн судалгааг улам бүр өргөжүүлсээр ирсэн байна. 1960-аад оны сүүлч үеэс МУИС-д герман хэл, соёлыг судлах болсон юм. 1990 оны Монголд гарсан ардчилсан хөдөлгөөний үр дүнд Монгол улсын бусад их, дээд сургуулиудад герман хэлийг судлах болсноор хэдэн мянган монгол хүний герман хэл, соёлыг судлах сонирхол улам нэмэгдсэн байна.

Монгол-Германы харилцаа 1990 оноос шинэ таатай

нөхцөлд өргөжин хөгжих болсноос хойш төрөл бус хэл болох монгол, герман хэлийг хэлзүйн бүтэц, зохион байгуулалтын талаас нь нэлээд дорвитой зэрэгцүүлэн судлах болсон. Ийм судалгааны бүтээлүүдэд Х. Наранчимэгийн “**Герман, Монгол хэлний зүйр цэцэн үгийн зэрэгцүүлсэн судалгаа**” (2001), Ж. Ариуны “**Герман, Монгол хэлний байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэрийн зэрэгцүүлсэн судалгаа**” (2004) бүтээлүүд зүй ёсоор тооцогдоно.

Монгол, герман хэлний өгүүлбэрийн бүтэц нь өөр зохион байгуулалттай, монгол хэл залгамал хэлний бүлэгт багтах тул өгүүлбэрийн цөм нь баруун байрлалтай, зүүн тийш салаалдаг бол герман хэл хувирамтгай хэлний бүлэгт багтах учир өгүүлбэрийн цөм нь зүүн байрлалтай, баруун тийш салаалдаг байна (жиш. Ж. Ариун 2004, 14).

Монгол хэлний өгүүлбэрийн илэрхийлэлд үйл үгийн идэвхгүй хэв бага хэрэглэгддэг бөгөөд өгүүлбэр нь зөвхөн цаг болон биеийн нөхцөлөөр төгсдөг байна. Герман хэлний өгүүлбэрт аливаа зүйлийг бодитой тодорхой дүрслэхийг эрмэлздэг бол монгол хэлний өгүүлбэрт шалтгаан, үр дагаврын учир холбогдлыг илэрхийлэхэд илүү анхаардаг байна. Герман хэлний өгүүлбэрийн бүтэц регрессив буюу хураагдах аргаар бүтэх нь түгээмэл байхад монгол хэлний өгүүлбэр угсармал аргаар бүтэх нь түгээмэл байдаг байна.

Монгол хэлний өгүүлбэрийн илэрхийлэл нь хялбархан ойлголцоход дөхөм болох үүднээс урьдаас оршилтой, тайлбар хийх нь олонтаа тохиолддог байхад Герман хэлний өгүүлбэрийн утгыг тайлахад хойноос нь эхэлж харах шаардлагатай ба илэрхийлэх байдал нь их **‘нарийн нягт’** байдаг байна.

Герман хэл бодит байдлыг илүү дүрсэлдэг гэж үздэг. Хэл, соёл, сэтгэхүй нь нягт шүтэлцээтэй байдаг тул үүнтэй маргах аргагүй юм. Төрөл бус хэлийг зэрэгцүүлэн судалж, тодорхойлолт өгөх, мөн түүнчлэн аливаа үндэстний соёлын шинж байдлыг тухайн хэлнүүдийн онцлог шинж чанаруудтай холбон тайлбарлаж дүгнэлт хийхдээ бас болгоомжлох нь зүйтэй юм.

Монгол, Герман үндэстнүүдийн эх хэлээ дээдэлж ирсэн уламжлал

Аливаа улс үндэстний эх хэл нь нэгдмэл болон тусгаар байдлыг хангахад мөн улс үндэстнээ цэвэр ариун байлгахад үйлчилдэг билээ. 17-18-р зууны үед Германы ихэс дээдсийн хүрээнд францын соёлын нөлөө гүнзгий тусч франц хэлээр харилцахыг эрмэлздэг байжээ. Автономит эрх мэдэл бүхий ван гүнгүүд тус тусдаа эрх мэдлээ булаацалдаж байсны улмаас Герман орон нь биеэ даасан төр улс болж чадахгүй байсан юм. Тиймээс үндэстний ухамсар муутай хэргэм зэрэгтнүүд францын ордны соёлыг ихэд дээдэлдэг байсан нь тухайн үеийн хүмүүсийн хоорондын харилцаа, барилга архитектур болон хэлэнд тусгалаа олсон байдаг.

Харин эх хэлээ дээдлэх үзэл дэлгэрч, 1733 оноос Германы их сургуулиудад герман хэлээр лекц унших болжээ. Герман улс нь олон үндэстний орон байсан тул герман хэлийг стандартчилах шаардлага зүй ёсоор урган гарч, 19-р зуунд бичгийн герман хэлийг стандартчилах асуудлыг анх ах дүү Гримм болон Конрад Дуден нар дэвшүүлэн тавьсан. 1871 онд Германы эзэнт гүрэн байгуулагдаж, хэлний бодлого зохицуулах эрхийг төр өөрийн эрх мэдэлдээ авч, улмаар Бисмаркийн нөлөөгөөр герман хэлийг түгээн дэлгэрүүлэх дотоод, гадаад бодлогын үзэл баримтлал бий болсон байна.



Орчин цагийн герман хэлний шинж чанаруудад нарийн төвөгтэй хэлзүйн дүрэм, товчлол, интернационализм, англицизм, неологизм зэргийг тооцож байна. Техникийн дэвшил шинэчлэл гарч, олон соёлын буюу олон улсын нөлөө, нийгэм, улс төр, эдийн засгийн харилцаа өргөжин тэлэхийн хэрээр герман, монгол хэлэнд төдийгүй дэлхийн бүх хэлэнд эдгээр өөрчлөлтүүд гарч байгаа нь ажиглагдах боллоо. Эдгээр өөрчлөлтүүдийг улс орон бүр янз бүрээр хүлээн зөвшөөрч байна². Англи хэлний нөлөө герман хэлэнд түрэн орж ирэх нь улам ихэссэнээс болж эх хэлээ цэвэр ариун байлгах хөдөлгөөн Германд өрнөж байна. Маннхайм хотын Герман хэлний хүрээлэн, германы их сургуулиудын дэргэдэх герман судлалын институтүүдийн эрдэмтэд герман хэлийг цэвэр ариун байлгах тал дээр тогтмол ажил санаачлан хэрэгжүүлдэг. Тухайлбал, герман хэлний зөв бичих дүрмийг шинэчлэн зохиож хэрэглээнд оруулах ажлыг хийсэн байна. Үүний зэрэгцээгээр Герман улс герман хэлийг гадаадын орнуудад түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимтэй өрнүүлж байгаа нь германы төрийн бодлогын нэг чухал зорилт юм. Герман улс дэлхийн улс орнуудтай хамтран ажиллах үйл ажиллагааныхаа хүрээнд соёлын хамтын ажиллагааг нэн чухалд авч үздэг бөгөөд энэхүү хамтын ажиллагааныхаа шугамаар “Германы соёл нь Европын соёлын нэгэн хэсэг” гэдэг утгаар нь германы соёл, хэлийг түгээн дэлгэрүүлэх, энэ талаар мэдлэг олгох нь чухал юм” гэж ХБНГУ улс төрийн бодлогынхоо үндсэн баримт бичигт тодорхойлсон байдаг. Германы хэл, соёлыг түгээн дэлгэрүүлэх үүрэг хүлээсэн Gёте институт, Германы эрдмийн солилцооны алба болон бусад сангууд дэлхийн олон оронд байдаг ч хэлний бодлогын асуудлыг Холбооны улсын төрөөс нэгдсэн бодлогоор зохицуулдаггүй харин ХБНГУ-ын муж улсуудын засгийн газар нь тус тусдаа шийддэг. Герман хэлийг хамгаалах асуудлыг илүү прагматик түвшинд шийдвэрлэдэг, тухайлбал, Маннхайм хотын герман хэлний институт нь герман хэлний зөв бичих дүрмийн асуудлыг, Дармштадт хотын “Германы академи” нь германы уран зохиолын асуудлыг, “Герман хэлний нийгэмлэг” нь герман хэлний толь бичиг, дүрэм, найруулгазүйн асуудлыг шийдвэрлэхэд тус тус анхаардаг байна.

Монголчуудын бичиг соёлын түүх өнө эртний улбаатай бөгөөд монголчууд бичиг үсгээ хэдэн зууны турш өөрчлөн сайжруулсаар ирсэн түүхтэй. Уйгаржин монгол бичгээр албан хэргээ хөтөлж явуулсан тэр цагаас (1204) хойш монголчууд түүхэндээ нийт 9 удаа бичиг үсгээ солих оролдлого хийж байжээ. Хамгийн сүүлд хуучнаар Зөвлөлт Орос улсын нөлөөнд автан Монгол улс кирилл бичиг үсэгтэй болсон билээ.

Монгол улсын хувьд, монгол хэл, соёлын асуудлыг эрхлэн явуулдаг байгууллага, хүрээлэн байдаг боловч ерөнхийдөө нэн хангалтгүй ажиллаж байна. Монгол хэлийг хэрэглэх хуульчилсан гол баримтлалыг 1992 оны 1-р сарын 13-нд УИХ-аар батлагдсан “**Монгол улсын Үндсэн хууль**” заан тогтоосон. Уг хуулийн наймдугаар зүйлийн нэгд “**Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн**” гэж заасан байна. Үндсэн хуулийн энэхүү суурь заалтад тулгуурлан 2003 оны 5-р сарын 15-ны өдөр УИХ-аас “**Төрийн албан ёсны хэлний тухай**” хууль батлагдаж, хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш “Төрийн хэлний зөвлөл” үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх эрхзүйн баримт бичигтэй болсон байна. Монгол улсын “Төрийн албан ёсны хэлний” тухай хууль нь Монгол үндэстний тусгаар тогтнол,

2 Америкийн компанийн News нэрийг ашиглан францын тамхины худалдаачин франц тамхийг борлуулсны улмаас 2000 долларын торгууль төлж байжээ.

үндэстний аюулгүй байдлын нэгэн баталгаа болж, гарвал төрх, үндсэн онцлогоо хадгалан ирсэн монгол хэлийг дэлхий нийтээр эдийн засаг, техник технологи, аж төрөх ёсны хувьд ч нийтлэг загварт ойртон нягтрах хандлага гарч буй даяаршлын эринд өвөрмөц онцлог шинжийг алдалгүйгээр Монгол улсын залуу хойч үе нь уламжлан өвлөж, төрийн үндэстний албан ёсны үйл ажиллагаа болон бүх нийтийн сургалт явуулах нийтлэг хэрэглүүр болгохын хамт үндэстний цөөнхийн хэлэнд хүндэтгэлтэй хандахыг онцлон тэмдэглэжээ. “**Төрийн албан ёсны хэлний**” тухай хуулийн хэрэгжилт төдийлөн хангалттай бус байгаа талаар холбогдох байгууллага, иргэд хэд хэдэн үндэслэлээр шүүмжилж байна:

төрийн бүх шатны байгууллагуудын албан бичиг хөтлөлт учир дутагдалтай,

төрийн албан ёсны хэлээр гарч байгаа олон нийтэд зориулсан хэвлэл, мэдээллийн хэлний хэм хэмжээ алдагдсан,

монгол хэлэнд нэвтэрч буй олон улсын нийтлэг нэртөмьёоны шинжлэх ухааны үндэслэл, орчуулгын байдал хангалтгүй сул,

нэртөмьёог оноон тогтоох, томилох, жигдлэх, дэлгэрүүлэх, мөрдүүлж хэвшүүлэх ажлын байдал тогтворгүй байна.

Төрийн зүгээс хэл, соёлын бодлогын асуудлыг дорвитой авч үзэхгүй бол бие биенээсээ үл хамааралтай янз бүрийн ашиг сонирхлын үүднээс нэгдсэн нийгэмлэг, холбоод үүсгэн байгуулагдах нь дамжиггүй юм.

Даяаршлын эринд Монгол оронд олон тулгуурт нээлттэй гадаад бодлого явуулах, олон нийт, ялангуяа залуу үеийнхэн дэлхийн шинжлэх ухаан, технологийн ололтыг эзэмшин хэрэглэх, бизнесийн харилцааг хөгжүүлэхэд тулгуур болох гадаад хэлийг түгээн дэлгэрүүлэх зорилт бол төрийн бодлогын чухал хэсэг байхын сацуу эх хэлнийхээ дархлааг буй болгохын тулд өнөөгийн монгол хэлний сургалтыг зарчмын хувьд өөрчлөх нь зүйтэй гэсэн саналыг манай хэл судлаач эрдэмтэд тавьж байгаа. Хэлний бодлогын талаар энд өгүүлж байгаатай холбогдуулан хүмүүжил, боловсролын зарчмын асуудлыг энд авч үзэх нь сонирхол татаж байна.

2.2 Боловсрол, хүмүүжлийн түвшин

Соёлын хэм хэмжээ бүрэлдэн бий болоход хүмүүжил, боловсрол шийдвэрлэх үүрэгтэй. Ийм учраас монгол, германы боловсрол, хүмүүжлийн зарчмыг харьцуулан авч үзэх нь сонирхол татахуйц байна. Монгол, германы боловсролын тогтолцоог авч үзвэл, үндсэн хоёр ялгаа харагддаг: (1) Монголын олон нийтийн боловсрол эзэмшүүлэх чиг хандлага бол шашны асуудлыг авч үздэггүй; (2) Германы боловсролын тогтолцоо нь холбооны улсын шинжийг хадгалсан байдаг, өөрөөр хэлбэл, улсаас нэгдсэн нэг бодлогыг тогтоодоггүй, тухайн холбооны муж улс нь өөрөө боловсролын бодлогоо тогтоон шийддэг гэсэн үг.

Германы боловсролын тогтолцоо нь бие даасан, чөлөөт, ардчилсан боловсролын үзэл санааг агуулдаг бөгөөд шаталсан зохион байгуулалттай. Герман хэлний Bildung буюу боловсрол хэмээх (sich bilden/өөрөө өөрийгөө боловсруулах гэсэн үгнээс гаралтай) үг нь бие даан, идэвхтэй оролцох гэсэн утгыг давхар илтгэдэг. Бие даасан, идэвхтэй оролцоонд багш, сурган хүмүүжүүлэгч нь туслан дэмжих үүргийг гүйцэтгэнэ.

Монгол улсын боловсролын асуудлыг БСШУЯ-наас гаргасан тогтоол, заавар удирдамжийг мөрдлөг болгон шийдвэрлэдэг. Тухайлбал сургууль төгсөх шалгалтыг нэгдсэн журмаар улсын хэмжээнд зохион байгуулж явуулдаг.



Улсын шалгалтын явцыг хэвлэл мэдээллийн бүх хэрэгслээр цацаж, сургалтын чанар үр өгөөжийн талаар багш, сурган хүмүүжүүлэгчид болон эцэг эхчүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, нэгдсэн санал дүгнэлтийг сонсдог. Төрөөс ийнхүү нэгдсэн бодлого баримтлан сургуулийн тогтолцоог хөгжүүлж байгаа нь нэгдсэн үнэлэмж, үлгэр жишээ, зарчим болон ажлын арга барил тогтох үндэс болдог байна. Ардчилсан төрт нийгмийг бүтээн байгуулах болсон цагаас эхлэн боловсролын салбарт уян хатан чөлөөт тогтолцоо бүрэлдэн бий болсныг тэмдэглүүштэй.

Германы ойлголтоор боловсрол нь бие даасан шинжтэй, идэвхтэй оролцоог эрхэмлэсэн, багш, сурган хүмүүжүүлэгч нь дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээсэн хүн байх юм. Германы эрдэмтэн Вильхелм Хумболдт **“Өөрийгөө эхлээд боловсруул, дараа нь чи юу эзэмшсэн түүгээрээ дамжуулан бусдад нөлөөл”** гэж хэлсэн нь монгол хэлний зүйр цэцэн үг **“Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас”** гэдэгтэй утга ойролцоо сонсогдож байна.

Герман улсад мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах хугацаандаа сургалтын явц, үйл ажиллагаанд хийсэн ажиглалтыг монголын сургалтын үйл явцтай жишиж үзвэл дараах байдалтай харагдаж байна:

- Багш суралцагчийн харилцаа нь монголтой харьцуулбал илүү нээлттэй, чөлөөт байдалтай.
- Германд сургалтын үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо их. Сургууль, багш нарын зүгээс эцэг эхийг тогтмол мэдээллээр хангах үүрэгтэй төдийгүй тэдэнд тогтмол мэргэжлийн зөвлөгөө өгдөг.
- Монгол хүний уламжлалт ойлголтоор бол багш хүн хамгийн эрхэм, хүндтэй хүн гэж ойлгогддог. Германы ойлголтоор бол багш хүн туслагч, дэмжигч, зөвлөгч, чиглүүлэгч хүн болно.

Герман улсад хүвийн амьдрал, сургууль гэдгийг маш нягт зааглаж ойлгодог. Хамгийн өргөн дэлгэр тархсан ойлголт бол **“Сургууль нь хүн болоод хүний амьдралд ээлтэй мэдээ мэдээлэл, мэдлэгийг түгээж, эзэмшсэн мэдлэгээ шинжиж, өөрийн үнэлэлт, дүгнэлтийг өгөх чадварыг олж авах, чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэх газар байх ёстой”** ба өөрийн үнэлэлт, дүгнэлтийг өгөх чадвар, чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэх нь германы уламжлалт сургалтын зорилго юм. Эртний уран илтгэх урлагт түшиглэсэн сэтгэлгээний болон илэрхийлэх хэлбэрийг сургуулилах сургуулиалт 17, 18-р зууны үеэс бий болсон. Исээ болон эхийг найруулан бичих нь герман хэлний хичээлийн үндсэн дасгалын хэлбэр бөгөөд энэ нь сонгож авсан зохиолоос иш татсан, уран илтгэх урлагийн нуансыг харуулсан бичлэгийн хэлбэр юм. Энэ бичлэг нь эсрэгцүүлсэн зохион байгуулалт, ангилалтай.

Герман улсын их сургуулиуд болон их сургуулийн боловсрол нь дэлхий даяар алдартай тооцогддог. Германчууд монголчуудыг бодвол харьцангуй хожуу албан тушаал ахиж, зэрэг цол хамгаалдаг, албан тушаалд сонгон шалгаруулах шалгаруулалт нь маш хатуу, тогтсон нөхцөл боломжийг биелүүлсэн байх учиртай. Тухайлбал, эдийн засгийн салбарт дээд албан тушаал хашиж байгаа хүмүүсийн шинжлэх ухааны мэдлэгийн түвшин маш өндөр, ерөнхий боловсролын суурь мэдлэг сайтай, уран илтгэх гайхамшигтай чадвар эзэмшсэн байх ёстой байдаг. Үүнтэй ижил түвшинд Монголын дээд албан тушаалтны байдлыг харьцуулан судалбал сонирхолтой байж болох юм. Монголын ерөнхий боловсролын сургууль төгсөгчийн мэдлэг, чадварын түвшинг Германы 9, 10 эсвэл 11

жилийн сургууль эсвэл гимнази төгссөн сурагчийн мэдлэг, чадвартай харьцуулж харвал, Монголын суралцагч ямар ч хөгжмийн нотыг алдалгүй уншиж чаддаг эсэх, ойд очоод ойд ургасан моддыг нэг бүрчлэн нэрлэж, юунд яаж ашиглаж болох талаас нь тайлбарлаж, бэлчээрийн ургамлын нэр усыг мэдэж тайлбарлаж чаддаг эсэх мөн химийн ямар элемент бидний амьдрал ахуйд ямар байдлаар хэрхэн яаж хэрэглэгдэж байгааг тайлбарлаж чаддаг эсэх, оршин суугаа газар орныхоо түүх, соёл, онцлог үйл явдлын талаар хүүрнэн өгүүлж чаддаг эсэхийг анзаарч дүгнэлт хийж болохоор байна.

Германы боловсрол илүү их практикт чиглэсэн, мэргэжлийн дадлага туршлага олгодог зэргээрээ илүү сайн мэргэшил эзэмшүүлдэг байна.

2.3 Харилцааны хэв маяг, мэдээлэл дамжуулах арга

Хэл шинжлэлийн үүднээс авч үзвэл, герман хэл монгол хэлийг бодвол илүү ил тод илэрхийлэлтэй байдаг. Монгол, герман хэлний хэрэглэгчид нь хэлний хэрэглэгдэхүүнээ янз бүрээр авч үздэг. Соёлын харьцуулсан судалгааны ажиглалт хийж байх явцад зарим соёл нь илүү **“low context”** харилцааны хэв маягтай байдаг. Ийм харилцаанд үгээр илэрхийлсэн, үгээр кодлогдсон мэдээллийг илүү дамжуулдаг. **“High context”** харилцааны хэв маяг бүхий соёлд далд утга санаа бүхий контекстийн утгыг тайлах, өөрөөр хэлбэл, битүү санаа агуулсан уялдаа холбоог тайлах нь чухал байна (жиш. Холл 1984, 36).

“Low-context”-ийн онцлог нь ерөнхий уялдаа холбоог бага анхаарч, нарийвчилсан мэдээллийг өгөхөд түлхүү анхаардаг ба тайлбарлах хэрэгцээ нэмэгдсэн, аман харилцааг бичгийн хэлбэрт (протокол, тэмдэглэл, техник ашиглалтын заавар г.м.) түшиглэн зохицуулж байдаг.

“High-context”-ийн онцлог нь ерөнхий уялдаа холбоог илүү анхаарч, тайлбар бага өгч, шууд бус илэрхийллийг илүүд үзэж, ёгт утгатай өөрөөр хэлбэл, битүүхэн хэлэх маягаар мэдээллийг дамжуулдаг. Дохио зангаа, биеийн хөдөлгөөн энд илүү оролцдог.

Энэ хоёр эсрэг тэсрэг байдлаас харьцуулж үзвэл, монгол-германы харилцаанд дараах ялгаатай тал ажиглагдана: германы харилцааны хэв маяг нь ерөнхий мэдээллээс илүү нарийвчилсан, тодорхой мэдээлэл өгдөг **“low context”**-д хамаарагдах бол монголын харилцааны хэв маяг нь илүү ерөнхий мэдээлэл өгдөг **“high context”**-д хамаарч байна.

Тэгэхээр өөр өөр контексттэй хүмүүс харилцаанд ороход үл ойлголцол болон түгшүүртэй байдал үүсэх нь гарцаагүй юм. **“High context”**-д түшиглэсэн харилцагч нь нарийн утга санааг ойлгох илүү их орон зайг гаргаж, тухайн харилцагчтайгаа нийцэхийг чухалчилдаг. **“Low context”**-д түшиглэсэн харилцагч нь илүү их мэдээллийг өгөх ба нарийн утга санааг ойлгох орон зайг бага гаргадаг. Ийм харилцагчид ямар асуудал учирч болохыг Холл (1984, 36) дараах байдлаар тодорхойлсон. “Хэрвээ мэдээллийн сүлжээ сийрэг байвал, хүмүүс уялдаа холбоог маш их анхаардаг, мэдээллийн сүлжээ нягт байхад анхаардаг хүмүүст тэдний мэддэг зүйлийн талаар өгүүлбэл, тэд ихэнхдээ тэвчээртэй бус, цочирдсон, цухалдсан байдлаар хариу үйлдэл үзүүлдэг. Үүний эсрэгээр ийм хүмүүс нь хэрвээ хангалттай мэдээлэл авч чадаагүй бол тэр аяараа арчаагүй байдалд ордог байна”. Цаад утга санааг агуулсан албан бус мэдээллийн хэмжээ хэдий чинээ бага байна төдий чинээ албан ба тодорхой мэдээллийн хэрэгцээ их байдаг байна.



Бүх соёлыг тухайн 'контекст'-ийн дагуу схемчлэх нь бэрхшээлтэй гэдгийг үл харгалзвал энэ загварыг хүлээн зөвшөөрөгчдийн хувьд нэгдсэн санал ойлголт одоогоор байхгүй байгаа юм. Энэхүү онолын үндэслэлээр монголын харилцааны хэв маягийг эдгээр хоёр туйлын хооронд тавьж үзэж болох юм.

Монгол хэлний харилцаанд үгээр шууд илэрхийлэх хандлага герман хэлтэй харьцуулбал харьцангуй бага байдаг эсэхийг судалж үзүүштэй юм.

Хоёр соёлын өөр өөр контекстийг зэрэгцүүлж үзэхэд, дараах ажиглалтыг хийж болж байна: германы албан байгууллага, газруудад өрөөний саалга нь ихэнхдээ хаалттай байдаг нь албан бус мэдээлэл солилцоход хүндрэл учруулдаг байж болох талтай. Тэгэхээр германы үйлдвэр, албан газар, компаниудад мэдээллийг дамжуулахад тогтмол албан ёсны хурал зөвлөгөөн хийх шаардлагатай болдог байна. Монголын хувьд амаар мэдээлэл дамжуулах нь түгээмэл байдаг бөгөөд хоёр соёлын энэхүү эсрэг тэсрэг зан байдал нь үл ойлголцол төрүүлж болохоор байна. Монгол-германы хамтарсан зөвлөгөөн, хэлэлцээрт германы талаас тухайлбал хамтарсан мэдээллийн байдлыг баталгаажуулахад илүү ач холбогдол өгдөг бол монголын талд мэдээллийг тухайн цаг хугацаанд дамжуулсан ч мэдээлэл хүрсэн эсэх талаар дахин нягталж баталгаажуулахыг төдийлөн анхаардаггүй.

Албан захидал харилцааг харьцуулан судалсан судалгаагаар германы байгууллага, компани нь өөрийгөө илэрхийлэхдээ илүү дэлгэрэнгүй бөгөөд мэдээллийг сайтар хангах байдлаар илэрхийлж байсан бол монголын захидал харилцааны хэв маяг, илэрхийлэл нь хэт ерөнхийлсөн байдалтай, нуршаа байдаг байна³. Герман хэлний эксплицит буюу тов тодорхой илэрхийлдэг байдлыг тухайлбал мэндчилгээний хэлбэрүүдээс анзаарч болно. Германы мэндчилгээний хэлбэрүүд нь өдрийн цагтай холбоотой байдаг. Монгол хэлний мэндчилгээ болох *сайн байна уу?* хэмээх хэллэг нь герман хэлний *Guten Tag* гэдэг хэллэгтэй ерөнхий утгаараа тохирох боловч илүү *Таны бие тэнхээ, ажил төрөл сайн байна уу?* гэсэн санааг давхар агуулж болох юм.

Монгол хэлнээс герман хэл рүү орчуулга хийхэд ажиглагдсан нэг зүйл бол герман хэл нь өгүүлбэрийн холбоосын тусламжтайгаар тусгай салангид утга санааг нарийвчлан илэрхийлэхийг шаарддаг. Жишээ болгож үр дагавар заасан өгүүлбэрийг авч үзье. *Er ist verletzt, so dass er nicht Sport treiben kann.* Энэ өгүүлбэрт үйлийн эзэн шархадсан тул спортоор хичээллэж чадахгүй болов гэсэн санааг дамжуулахдаа *so dass* гэсэн өгүүлбэрийн холбоосыг ашигласан байна.

2.4 Хэл ярианы хэв маяг. Ярианы утга учир

Монгол-германы харилцан ярианд, тухайлбал өдөр тутмын болон албан ажлын яриа хөөрөө буюу харилцаа, утсаар ярих, гэрээ хэлэлцээр хийх онцгой тохиолдол зэрэгт ярианы зан байдал нь оролцогчдод янз бүрээр илэрдэг 3 Албан бичгийн орчуулгын хичээлээр монгол, германы захидал харилцааны бүтэц, хэв маяг, хэл найруулгад анализ хийж үзсэн билээ. Захидлын толгойлсон байдал, захидлын утга агуулга (ажлын байр хүссэн захиа, тэтгэлэг хүссэн захиа) зэргээс судалгаа хийж үзэхэд герман хэлний илэрхийлэл нь тухайн холбогдох асуудалдаа илүү ажил хэрэгч байдлаар хандсан, нарийвчилсан бөгөөд тодорхой шууд мэдээллийг өгсөн байна. Монголын бичгийн харилцаанд харин тухайн утга агуулгыг сайхан уянгалаг, сонсголонтой байхад илүү анхаарч, тухайн хэлэх гэсэн санаа нь хамгийн эцэст шууд бус дамжин ойлгогдохоор байна.

4 Холлын онолтой жишиж үзэх. 1984

байна⁴. Үүнээс юу гэж ойлгож болох вэ гэвэл ярианы янз бүрийн хэм хэмжээ байдаг гэсэн таамаг дэвшүүлж болох юм.

Conversation буюу яриа хөөрөө хэмээх үгний үндсэн утгын талаар эхлээд тайлбарлая: германчуудын хувьд яриа хөөрөө нь нийгэм-соёлын ямар ач холбогдолтой вэ? Энэ асуудлын талаар герман-америк хүмүүсийн харилцаанд гарах үл ойлголцох байдлыг Холл болон бусад эрдэмтэд судалж үзсэн байдаг. Германы ойлголтоор бол *conversation* гэдэг нь *Engagiertheit* (оролцоо; чин зүтгэл), *Unterhaltung* (яриа хөөрөө; хөгжөөн наргиан), *Brillanz* (гайхалтай чадвар; хурц тод) хэмээх хэд хэдэн шинжийг хадгалсан байдаг байна.

Герман хэл дээр яриа явагдаж байхад яриаг таслах нь дамжуулсан мэдээллийн утга санааг ойлгоход хүндрэлтэй байх болно. Герман хэлний хавсарсан нийлмэл өгүүлбэрт мэдээлэл дамжуулагч гол үйл үг нь өгүүлбэрийн эцэст орсон байдаг. Яриаг дундуур нь таслах нь үл хүндэтгэсэн болон тухайн яриа сонирхолгүй байна гэсэн санаа биш юм. Харин ярианд идэвхитэй оролцож буйгаа илтгэнэ. Холлын үзэж байгаагаар "Германчууд тухайн асуудлын талаар авч үзэхдээ тойруу замаар биш шууд асуудалдаа ордог. Баримт мэдээ болон тусгайлсан мэдээнд үнэхээр дуртай" гэжээ. Харин монголчуудын хувьд эхлээд асуудлын ерөнхий байдлыг ярьж ойлгуулахыг чухалчилдаг. Тухайлбал ажил хэргийн уулзалтаар зоог барихдаа ажил хэрэгтэй холбоотой сэдвийг хооллож дуусах үедээ хөнддөг. Монголчуудын ойлголтоор зөвхөн тухайн ажил хэргийн харилцааг өрнүүлэхээс гадна харилцагчтайгаа эерэг нааштай харилцаа тогтоохыг хичээдэг.

Утсаар харилцаа өрнүүлэхэд үгэн бус контекст байдаггүй тул ихэнхдээ хэцүү гэж үздэг. Мэдээлэл олж авах нь хэлний ба паравербаль тэмдэгтээр хязгаарлагдсан байдаг. Гадаад хэлээр харилцагчийн хувьд эдгээр хүчин зүйлс нь найдвартай байж үл чадна. Монгол хэлээр шууд ил тод илэрхийлэх нь бага байдаг гэж үзвэл монголчуудтай утсан харилцаагаар харилцахад хүндрэл учирч болзошгүй юм. Германчууд хувийн болон албаны аль ч асуудлаар утсаар ярихдаа эхэлж өөрийн овог нэрээ хэлдэг заншилтай бол монголчууд утсаар яриагаа эхлэхдээ өөрийнхөө нэрийг эхэлж тэр болгон хэлж заншаагүй байдаг.

Гадаад хэлээр утсаар харилцахад бэлтгэх тусгай сургалтыг зохион байгуулах нь зүйтэй юм.

2.5 Дохио зангаа болон биеийн хөдөлгөөн

Дохио зангаа болон биеийн хөдөлгөөний (**body language**) талаар 60-аад оны сүүл үеэс барууны орнуудад түлхүү судлах болсон. Энэ талаарх судалгаа тодорхой түвшинд хүрсэн ч гэсэн гадаад хэл сургах, заах аргазүйн салбарт өнөөг хүртэл дорвитой нэвтрүүлээгүй байна. Дохио зангаа, нүүр царайны хувирал, биеийн хөдөлгөөний байдлаар мэдээлэл дамжуулж байдаг. Вацлавскийн үзэж байгаагаар дохио зангаа нь аналог харилцааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд энэ харилцааны явцад тэмдэгт болон тэмдэглэгдсэн зүйл хоёрын хооронд сайн дурын харьцаа үүсдэггүй. Дохио зангаа нь тогтсон контекстэд хамаарагддаг. Тухайн контекст нь дамжуулсан мэдээллийг тайлахад гол үүрэг гүйцэтгэдэг. Биеийн хөдөлгөөний дохионууд нь хэлний тэмдэгтийн адил үл ойлгогдож болох талтай. Харилцааны явцад хөдөлгөөний хэмнэл нь (алхаа гишгээ, биеэ авч яваа байдал, булчин чангалах, амрах) ухамсарт зайлшгүй хүрэх сэтгэгдлийг үлдээдэггүй. Үг болон биеийн хөдөлгөөний



дохионуудын хооронд тохироо байдаггүйгээс харилцагчийн жинхэнэ, бодит байдал дутуу дулимаг болж тодорхой бус мэдрэмж үүсдэг байна. Монголчууд болон германчуудын хооронд соёлын онцлогийг харуулсан ялгаатай шинжүүд тэдгээрийн биеийн хөдөлгөөний илэрхийлэлд байдаг эсэхийг тусгайлан судлах нь сонирхолтой байж болох юм. Биеийн хөдөлгөөний тэмдэгтүүдийн олон талт байдлын талаар тайлбар өгсөн ганц сэдэвт зохиолуудад олон улсын хэмжээнд өөр өөр байдаг мэндчилгээ, талархал, зөвшөөрөх, татгалзах, хүлээн зөвшөөрөх, шүүмжлэх, үл итгэх, баяр баясгалан зэргийг илтгэсэн янз бүрийн илэрхийллийг нэрлэж болно. Чухам эдгээрийн аль нь нийтлэг герман, нийтлэг монгол байж болох вэ? Эдгээр зохиолууд буюу нэвтэрхий тольд зааснаар нийтлэг дохио зангаа нэлээдгүй байна. Монголчуудын нийтлэг дохио зангаа, биеийн хөдөлгөөний талаар зураглан харуулсан нэвтэрхий толь буюу бүтээл өнөөг хүртэл хийгдээгүй байгаа юм. Харин зохиолч Л. Түдэвийн бичсэн “Монгол ёсон V” ботид монгол дохио зангааны талаар дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. Боловсрол нэмэгдэхийн хэрээр биеийн хэлний буюу хөдөлгөөний амьд цоглог хэлбэр буурдаг болох нь ажиглагдсан байдаг. Биеийн хөдөлгөөний үзэгдлүүдийг шинжлэхэд нас ба хүйс чухал үүрэг гүйцэтгэдэг. Вайлегийн (1981) үзэж байгаагаар хүүхдүүд насанд хүрэгчдийг бодвол дохио зангааны асар их урын сантай байдаг аж. Харин эмэгтэйчүүд эрчүүдийг бодвол дохио зангаа, нүүр царайны хувиралыг илүү их үзүүлдэг байна. Дохио зангаа хэрэглэх нь тухайн хүний хэр

их гадагшаа чиглэсэн зангаас хамаардаг байна. Герман хүний гаргадаг нийтлэг дохио зангааны талаар Семи Молхо тодорхойлохдоо: “Германчууд хүнтэй харилцахдаа тухайн хүнийхээ нүд рүү нь харж ярих дуртай. Нүд бол хүний сэтгэлийн толь.” гэж үзсэн байна.

Монгол хүний дохио зангаа тун өвөрмөц байдлаар илэрдэг болохыг эрдэмтэн зохиолч Л. Түдэвийн тэмдэглэн бичсэнээр “Монгол дохио бол олон төрөл зүйлтэй бодит болоод хийсвэр хэлбэртэй харилцааны хэрэглүүр төдийгүй уран сайхны, гүн ухааны, шашин шүтлэгийн, ахуйн шинжийг агуулсан мэдээллийн цогцолбор арга хэрэглүүр юм. Монгол дохио нь гар дохио, бие дохио, дуут дохио, дүрст дохио, галт дохио, утаат дохио гэсэн гол 6 төрөлтэйгээр харилцаанд хэрэглэгдэж ирсэн” (Л. Түдэв 2005:240) болохыг дурджээ.

Кино урлаг хөгжсөний ачаар биеийн хөдөлгөөнийг судлах боломж нээгдсэн билээ. Германы мэргэжилтэн багшийн тодорхойлсноор монгол оюутнуудын үйл хөдөлгөөнийг хичээлийн явцад ажиглавал тэд ихэвчлэн харц доогуур, дуугаа хураасан байх нь илүү түгээмэл гэж үзжээ. Гэвч энэ нь академик сургалтын явцад илрэх тул нарийн үр дүнг хэлэлцүүлэхэд хязгаарлагдмал байж болох талтай. Ажиглалтын явцаас дүгнэж хэлбэл, Оюутнууд сууж байх явцада элгээ тэврэх эсвэл гар утсаараа байнга оролдох нь хичээлд төвлөрөхөд үргэлж хүндрэлтэй байдаг байна.

Хувь хүний өөрийгөө илэрхийлэх олон талт байдал нь янз бүрийн утга санааг илэрхийлж болох юм гэсэн таамаг дэвшүүлснийг дараах хүснэгтүүдээс харж болно:

А) Дүр байдал

Илэрхийлж буй шинж тэмдэг	Илэрхийлж болох утга санаа
Цээжин биеэ бөхийх	сонирхсон, анхааралтай, сэтгэл догдолсон
Цээжин биеэ арагш гэдийлгэх	өөртөө итгэлтэй, эргэцүүлсэн эсвэл сонирхолгүй
Нуруугаа мурийлган мөрөө дээш өргөсөн	итгэлтэй бус, аймхай, магадгүй урам хугарсан
Толгойгоо өргөх	оюун бодлыг дээдэлсэн, хамтарсан
Толгойгоо арагш нь гилжийлгэх	өөрийн ухамсартай, омог бардам, магадгүй ихэмсэг, ойртоход бэрх
Толгойгоо доош нь буулгасан	тээнэгэлзсэн, урам хугарсан
Толгойгоо нааш цааш нь хөдөлгөх	шийдэмгий бус, болгоомжилсон, эргэцүүлсэн

Б) Дохио зангаа

Дохио	Илэрхийлж болох утга санаа
Дээшээ дэлгэсэн гар	тайлбарласан, харуулсан
доороос дээш чиглэсэн хөдөлгөөн	гуйсан, хүлээсэн
дээрээс доош чиглэсэн хөдөлгөөн	бэлэглэсэн, ямар нэг юм дамжуулсан
Доош дэлгэсэн гар	хяналтаа алдах
доороос дээш чиглэсэн хөдөлгөөн, гараа унжуулах	туслах аргагүй байдалд орсон, урам хугарсан
доороос дээшээ удаан шат ахисан хөдөлгөөн	тодорхой, логик дараалал бүхий санаабодол
Гарын алгыг гадагш нь эргүүлсэн	дайралтыг няцаасан, зай барьсан
Гараа чангалсан	итгэлтэй бус, айсан, тайван бус
Гараа чанга атгасан	шийдэмгий бус
Гараа зангидсан	шийдэмгий, магадгүй уур нь хүрсэн
Гараа амандаа хүргэсэн	гайхсан, түр зуур итгэл алдарсан
Гараа хацартаа тулсан	бодлогоширсон, эргэцүүлж бодсон

**В) Нүүр царайны хөдөлгөөн**

Илэрхийлж буй шинж тэмдэг	Илэрхийлж болох утга санаа
Нүүр тулах	нээлттэй, сонирхсон
Нүүр буруулах	бодлогоширсон, тээнэгэлзсэн, магадгүй татгалзсан
Хөмсгөө өргөх	гайхсан, эргэлзсэн, төвлөрсөн
Уруулаа цорвойлгох	үл тоосон, доош нь хийсэн
Амаа үл ялиг жимийх	тайван, санал нэг байгааг илэрхийлэх
Амаа сайн жимийх	шийдэмгий, үйлдэл хийхэд бэлэн, гэхдээ тайван бус
Хоёр уруулаа хазах	тайван бус, төвлөрсөн

Дээр дурдсан биеийн хөдөлгөөний илэрхийллүүд өдөр тутмын харилцаанд байнга илэрдэг ч эдгээрийн илэрхийлж болох утга санааг хүн бүр янз бүрээр харуулж мөн түүнчлэн өөр өөрөөр тайлж ойлгож болно. Хэлний олон салаа утга эсвэл тухайн харилцагчийн тааж мэдэхэд бэрх бодол санаанаас болж үл итгэх байдал үүсч болох харилцааны үед тухайн контекстийг ойлгомжтой байдлаар илэрхийлэх нь маш чухал юм. Хэрвээ хэлний илэрхийллийг дагалдан үл ялиг далд санааг агуулсан биеийн хөдөлгөөний тохироо дутуу дулимаг байх нь харилцагчийн бие биедээ итгэж харилцах байдалд иөлөөлж болох талтай юм.

ДҮГНЭЛТ

Дээрх харьцуулалтаас харвал, монгол, германы хоорондын харилцаанд гарах ялгаатай талууд нь харилцааны чухал чухал аспектиудад тухайлбал, хэл ярианы (үгэн/үгэн бус), харилцан яриа өрнүүлэх, үнэлэмж зэрэг салбарт тод илэрдэг байна. Бидэнд мэдэгдэж байгаа харилцааны үйл явц нь янз бүрийн хүчин зүйлээр тодорхойлогдож болох тул юуны өмнө тэдгээрийн нөлөөлөх ухамсарыг бий болгох хэрэгтэй.

НОМЗҮЙ**Монгол хэлээр:**

- Ариун, Ж. "Герман, Монгол хэлний байц гишүүн өгүүлбэртэй угсаарсан нийлмэл өгүүлбэрийн зэрэгцүүлсэн судалгаа", Диссертаци, Уб., 2004.
- Дулдуйтын Данзан Равжаа. "Цагийн жамыг тодруулагч Цаасан шувуу"
- Наранчимэг, Х. "Герман, Монгол хэлний зүйр цэцэн үгийн зэрэгцүүлсэн судалгаа", диссертаци, Уб., 2001.
- Түдэв, Л. Монгол ёсон, Уб., 2005, 240 тал

Англи, герман хэлээр:

- Ager, Dennis (Hrsg.): *Language education for intercultural communication*. Clevedon [u.a.]: Multilingual Matters, 1993.
- Barkmann, U. (1991), *Einige Bemerkungen zum Problem des Eides in der «Geheimen Geschichte der Mongolen*.
- Bormann, R. , Bormann, Klaus-Dieter (1998), *Verhalten in der Mongolei*. Doefler, G. (1964), *Die mongolische Schriftsprache*.
- Gudykunst, William B/Young Yun Kim (Hrsg.) (1984), *Methods for intercultural communication research* Beverly Hills: Sage, 1984.
- Hall, Edward T/ Hall, Mildred Reed: *Understanding cultural differences*. Yarmouth, Me.: Intercultural Press, 1990.
- Heringer, Hans Jьrgen, (2007), *Interkulturelle Kommunikation: Grundlagen und Konzepte*. Tьbingen [u.a.]: Francke, durchges. Aufl.
- Kumbier, Dagmar u.a. (Hrsg.) (2008), *Interkulturelle Kommunikation Methoden, Modelle, Beispiele*. Reinbek bei Hamburg: Rowohlt-Taschenbuch-Verl., 2008, 2. Aufl.
- Lьsebrink, Hans-Jьrgen, (2008), *Interkulturelle Kommunikation: Interaktion, Fremdwahrnehmung, Kulturtransfer*. Stuttgart [u.a.]: Metzler, aktualisierte und erw. Aufl.
- Renate Bauer-Radnaa (1969), *Akkusativ und Genitiv des Subjekts in mongolischen Glied- und Nebensätzen*
- Straub, Jьrgen, (2007), *Handbuch interkulturelle Kommunikation und Kompetenz: Grundbegriffe - Theorien - Anwendungsfelder; mit Tabellen*. Stuttgart [u.a.]: Metzler.
- Wayers, M. (1996), *Untersuchungen zu einer historischen Grammatik des prьklassischen Mongolisch*. Bonn